

2024 оны 12 сарын 06-ны өдөр

№ 23

Улаанбаатар хот

**Биржийн бус зах зээлд компанийн өрийн хэрэгсэл гаргах тухай**

Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 42.1, 43 дугаар зүйлийн 43.1, 55 дугаар зүйлийн 55.2, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.6, 80 дугаар зүйлийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1, 16.3.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 955 дугаар тогтоолоор батлагдсан “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэг, МҮЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн 2022 оны 22/41 тоот тогтоолоор баталж, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 17 тоот тушаалаар батламжилсан “Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.1 дэх хэсэг, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.2, 8.6.12, 8.6.23, 8.10 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2024 оны 12 сарын 04-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компани нь нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50,000 (тавин мянга) ширхэг, нийт 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг (цаашид “Бонд” гэх) Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Биржийн бус зах зээлд арилжаалахаар гаргасугай.
2. Компанийн Бондыг хаалттай хүрээнд санал болгох нөхцөл, татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалтыг хавсралтаар баталсугай.
3. “Онч кредит рэйтинг эйжинси” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн “Санхүүжих чадавхийн зэрэглэл тодорхойлох тайлан”-гаар Компанийн санхүүгийн чадавхийн зэрэглэлийг “mPA-” “тогтвортой” түвшинд гэж тогтоосныг дурдсугай.
4. Энэхүү тогтоолын дагуу хаалттай хүрээнд Бонд гаргахтай холбоотойгоор Үндсэн андеррайтераар “Эс Жи капитал ҮЦК” ХХК, туслах андеррайтераар “Стоклаб секюритиз ҮЦК” ХХК, Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх байгууллагаар “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-ийг тус тус сонгож, холбогдох гэрээ байгуулахыг Компанийн гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолын дагуу Бондыг биржийн бус зах зээлд арилжаалах үйл ажиллагааг зохион байгуулж, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Санхүүгийн зохицуулах хороонд зохих журмын дагуу бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

  


“Сэндли ББСБ” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 23 дугаар тогтоолын Хавсралт №01

КОМПАНИЙН БОНДЫГ ХААЛТТАЙ ХҮРЭЭНД  
БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАХ НӨХЦӨЛ

№	Үзүүлэлт	Нөхцөл
1.	Үнэт цаасны нэр	“Сэндли Бонд”
2.	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	Монголын Үнэт цаасны Арилжаа эрхлэгчдийн холбооны Биржийн бус зах зээл
3.	Үнэт цаасны төрөл	Энгийн хүүтэй бонд (өрийн хэрэгсэл)
4.	Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	5,000,000,000 (таван тэрбум) төгрөг
5.	Бондын тоо ширхэг	50,000 (тавин мянга) ширхэг
6.	Нэгж бондын нэрлэсэн үнэ	100,000 (нэг зуун мянга) төгрөг
7.	Бондын хугацаа	24 (хорин дөрөв) сар
8.	Бондын хүү (жилийн буюу 365 хоног)	20% (татварын өмнөх)
9.	Хүү төлөгдөх давтамж	Улирал тутамд
10.	Үндсэн төлбөр төлөх хугацаа	Бондын хугацааны эцэст (24 сарын дараа)
11.	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх
14.	Бондын барьцаа/баталгаа	“Онч кредит рэйтинг эйжинси” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн “Санхүүжих чадавхийн зэрэглэл тодорхойлох тайлан”-г үндэслэн барьцаагүйгээр гаргах (Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 16.3.2 дахь хэсэг);
15.	Үндсэн андеррайтер	“Эс Жи Капитал ҮЦК” ХХК
16.	Туслах андеррайтер	“Стоклаб секьюритиз ҮЦК” ХХК
17.	Үнэт цаасны бүртгэл, хадгалалт	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
18.	Үнэт цаас гаргахаар төлөвлөж буй хугацаа	2024 оны 12 дугаар сард багтаах